

АНГИЛАЛЫН ДҮРМҮҮД СУРГУУЛИЙН ДҮРМҮҮДИЙН ХАВСРАЛТ № 1

Ерөнхий тойм

№ 561/2004 дугаарын сургуулийн өмнөх боловсрол, бага сургууль, дунд сургууль, дээд мэргэжлийн болон бусад сургалт боловсролын актын (цаашид Боловсролын Акт гэнэ) дагуу, сургуулийн хууль зүйн асуудал хариуцагч миний бие, доорх зааварчилгааг толилуулж байна.

Энэ зааварчилгаа нь Боловсролын Актын нэг хэсэг болох (“Сургуулийн Дүрмүүд, сурагчид ба оюутнуудын сургалтын дүн гаргах дүрмүүдийг агуулна”) 30/2/ Хэсэгтэй хамт Сургуулийн Дүрмийн нэгэн хэсэг болж байгаа. Тус удирдамжтай сургуулийн веб хуудсаар орж танилцаж болох ба Боловсролын Актын 30-р Хэсгийг дагаж үзэх боломжтой; сургуулийн ажилчид ба сурагчид /оюутнууд/ үүнтэй танилцсан ба бага насны хүүхдүүд ба сурагчдын хууль ёсны төлөөлөгчид үүний нийтлэл ба агуулгын талаар мэдээлэл авсан болно.

АГУУЛГА

1. Хичээл дүгнэлт ба сурлагын дүн, сургуулиас зохион байгуулж байгаа арга хэмжээ ба сурагчдын сахилгын тухай ерөнхий ойлголт ба зарчмууд
2. Сургуульд ба сургуулиас зохион байгуулж байгаа арга хэмжээнд сурагчийн сахилгыг дүгнэх
3. Сурагчдын өөрийгөө үнэлэх үнэлгээний дүрмүүд ба зарчмууд
4. Ангилалаар сурлагын дүнг гаргах ба сахилга дүгнэх шатлалууд
5. Сургуулийн зэрэглэлүүд ба түүний шинж чанар, урьдчилан тогтоосон шалгуурууд
6. Комисс ба хяналтын шалгалтуудын тухай нарийвчлалууд
7. Бага сургуулийн ба хяналтын шалгалтыг дахин шалгах комиссуудын хоорондын ялгаа
8. Гадаад дахь сургуулиудын шалгалтууд
9. Дүгнэлтийн баримт бичиг авах арга барил
10. Тусгай сургалт шаардлагатай сурагчдыг дүгнэн үнэлэх арга барил
11. Гоц авьяаслаг хүүхдүүд, сурагчид ба оюутнуудын дүгнэлт
12. Зохисгүй ба эрсдэлтэй байдлаар биеэ авч явахыг шүүж дүгнэх дүрмүүд
13. ТӨГСГӨЛИЙН ТОЙМ

БОЛОВСРОЛ БА САХИЛГА ДҮГНЭХ ДҮРМҮҮД

1. Сургууль ба сургуулиас зохион байгуулж байгаа арга хэмжээнд оролцож байгаа байдлаас зан байдал ба боловсролын түвшинг дүгнэх ерөнхий зарчмууд

- a) Сурган хүмүүжүүлэх ажилчид, сурагчид, оюутнууд, хүүхдүүд ба бага насы сурагчдыг төлөөлж байгаа тэдний хууль ёсны төлөөлөгчид, эсвэл бага насы сурагчид ба оюутнуудын өмнө аливаа нэгэн хариуцлага хүлээсэн зохих хүмүүс хариуцсан хүүхэд, сурагч эсвэл оюутны сургалт боловсролын дүнгийн талаар мэдээллийг цагт нь тогтмол авч байх үргийг хүлээнэ.
- b) Хичээлийн хагас жил бүр сурагчид хичээлийн тайланг хүлээн авна; сурагчдад бүрэн бүтэн тайлангийн оронд тайлангийн хэсгийг гардуулна.
- c) Тайланд сурагчийн сургалтын дүнгийн дүгнэлтийг үечлэн шатласан байдлаар хийнэ ("ангилал"-ын дараагаар). Хариуцагч багш дүгнэлтийн арга барилын сонголтыг шийднэ.
- d) Хэрэв сурагч сургуульдаа хууль ёсны төлөөлөгчийн гаргасан санал хүсэлтийн дагуу ямар нэгэн өөр байдлаар дүгнүүлэх хүсэлтэй бол сургууль нь ангилалыг амаар дүгнэх дүгнэлт болгож хувиргаж болно.
- e) Хэрэв сурагч нь биеийн хөгжилд гарсан өөрчлөлтийн улмаас суралцах чадвар супларсан бол хариуцсан багш нь сурагчийн хууль ёсны төлөөлөгчийн хүсэлтээр амаар дүгнэх аргыг хэрэглэх эсэхийг шийднэ.
- f) Ерөнхий боловсролын сургуулийн сурагч нь хэрэв жилийн хоёр дахь хагасын эцсийн хичээлийн дүгнэлтэнд тэнцээгүй эсвэл түүнийг ямар нэгэн шалтгаанаар дүгнэх боломжгүй болсон тохиолдолд тус хичээлийн жилээ дахин давтах ёстой. Энэ нь бага сургуулийн хичээлийн жилийг дахин давтаж сурсан сурагчдад хамаарахгүй.
- g) Сургуулийг төгссөн, гэхдээ хичээлийн жилийн хоёр дахь хагасын эцэст амжилтгүй үзүүлэлттэй эсвэл дүгнэх боломжгүй тохиолдолд хариуцагч багш нь сурагчийн хууль зүйн төлөөлөгчтэй хамтарч түүний эцсийн дүнг гаргаж, өргөдөл дурьдсан шалтгаануудыг харгалзан хүүхдийг тус хичээлийн жилийг дахин давтах зөвшөөрлийг олгоно.
- h) Боловсролын талаар авах арга хэмжээнд шагнал эсвэл аливаа нэгэн өөр төрлийн урамшуулалт болон сахилгын арга хэмжээ зэрэг ордог. Сахилгын арга хэмжээ нь сурагч эсвэл оюутныг сургууль болон сургуулийн байгууллагаас хасах арга хэмжээ, сурагч эсвэл оюутанд аливаа нэгэн хууль зүйн нөлөө үзүүлэхгүй өөр ямар нэгэн арга хэмжээ ч байж болно. Сайшаал шагналууд, эсвэл бусад өөр нэгэн сахилгын арга хэмжээг сургуулийн тэргүүлэх багш эсвэл сургуулийн байгууллага, аль эсвэл ангийн багш ноогдуулж өгдөг. Сургуулийн тэргүүлэх багш эсвэл байгууллагын захирал нь энэхүү Актын нөхцлийдийг маш ноцтой зөрчсөн үед эсвэл сургуулийн дотоод дүрэм журмыг ноцтой зөрчсөн тохиолдлуудад сурагч буюу оюутныг сургууль болон сургуулийн байгууллагаас нөхцөл байдлуудыг харгалзангаа хасах эрхтэй. Нөхцөл байдлуудыг харгалзаж

сургуулиас хассан тохиолдолд сургуулийн тэргүүлэх багш эсвэл сургуулийн байгууллагын захирал нэг жилээс хэтрэхгүй туршилтын засах хугацааг тодорхойлно. Хэрэв туршилтын хугацаанд сургач эсвэл оюутан нь Актыг дахин зөрчиж сургуулийн дотоод дүрмийг зөрчсөнтэй адил нэгэн ноцтой зөрчил давтан гаргасан бол сургуулийн тэргүүлэх багш эсвэл сургуулийн захиргаа нь түүнийг сургуулиас бүрмөсөн хасах шийдвэр гаргана. Сургач сургуульд зайлшгүй хүрэлцэн ирэх нөхцлийг бүрдүүлсэн тохиолдолд л зөвхөн сургуулиас бүрмөсөн хасагдах эрхтэй.

- i) Сургач эсвэл оюутан нь сургуулийн эсвэл сургуулийн байгууллага захиргааны ажилтнуудыг, сургуулийн дотоод ажилчдыг үгээр доромжлох эсвэл биед халдлага өртөлт үйлдэхийг маш ноцтой зөрчилд тооцож, энэхүү Актаар тэр хариуцлага хүлээлгэнэ.
- j) Нөхцөл байдлыг харгалзан сургуулиас сургач эсвэл оюутныг хасах эсэхийг тэргүүлэх багш эсвэл сургуулийн байгууллага захиргаа нь түүний буруу хэрэг үйлдсэн цагаас тоолж хоёр сарын хугацаанд шийдэх ёстой ба, хэрэв зөрчил нь тусгай хууль зүйн зохицуулалтаар хуулийн дагуу эрүүгийн хэрэг гэж тооцогдсон байвал зөрчил үйлдсэнээс эхлэн жилээс хэтрэхгүй хугацаанд сургуулиас хасах асуудлыг шийдвэрлэсэн байх шаардлагатай. Сургуулийн тэргүүлэх багш нь Сурган Хүмүүжүүлэх Зөвлөлийг энэхүү шийдвэртэй танилцуулна. Сургач эсвэл оюутан нь, хэрвээ өөр тусгай огноо тавьж тодорхойлоогүй бол сургуулиас хасах шийдвэр батлагдсан огнооноос тоолон дараачийн өдрөөс сургууль буюу сургуулийн байгууллагын сургач эсвэл оюутан байхаа больж хасагдана.

2. Сургууль ба сургуулиас зохион байгуулах арга хэмжээнд оролцсоноос сахилгыг дүгнэх

- a) Сурган хүмүүжүүлэх зөвлөлийн хэлэлцүүлгийн дараа тэргүүлэх багш нь түүний хувийн шийдвэрийн үндсэн дээр эсвэл бусад өөр нэгэн хууль зүйн эсвэл ойр дотны хүний санаачилгаар түүний хагас жилийн амжилттай үйл ажиллагааг үнэлсний бэлэг тэмдэг болгож, эсвэл аливаа нэгэн иргэний хариуцлагын зоригтой үйлдэл хийснийг харгалзаж, үүний уламжлал болгон сайшаал, шагнал эсвэл ямар нэгэн өөр төрлийн урамшуулалт гардуулах эрхтэй.
- b) Сургуулийн тэргүүлэх багштай ярилцсаны дараа анги хариуцсан багш нь өөрийн шийдвэрийн үндсэн дээр, эсвэл бусад багш нарын санаачилгаар сургачид удаан хугацааны амжилттай сурлага эсвэл сургуулийн арга хэмжээнд оролцож сайн санаачлага гаргасны улмаас олгох сайшаал урамшуулалт эсвэл өөр нэгэн шагнал гардуулах эрхтэй.
- c) Сургуулийн Дүрмэнд заагдсан хариуцлагуудыг биелүүлээгүй, зөрчсөн тохиолдлуудад зөрчлийн ноцтой байдлыг харгалзан сургач доорх төрлийн шийтгэл авч болно:
 - a. Ангийн багшийн сануулга;
 - b. Ангийн багшийн албан ёсны сануулга;
 - c. Сургуулийн тэргүүлэх багшийн албан ёсны сануулга.
- d) Ангийн багш нь хэрвээ ангийн сануулга өгсөн бол сургуулийн тэргүүлэх багшид тэр даруй үүний тухай мэдэгдэх ёстой. Захирлын сануулгыг зөвхөн

Сурган Хүмүүжүүлэгчийн Зөвлөлөөр орж хэлэлцэсний дараагаар сурагчид танилцуулах ёстой.

- e) Сургуулийн тэргүүлэх багш эсвэл ангийн багш нь сурагч эсвэл түүний хуулийн төлөөлөгчид сайшаал урамшуулалт эсвэл аливаа нэгэн өөр шагнал эсвэл сануулга зэмлэлийн тухай үүний шалтгаануудыг хавсрان нэн даруй мэдэгдэж байх үргийг хүлээнэ.
- f) Сайшаал эсвэл өөр нэгэн шагнал болон сануулга зэмлэл зэрэг үйлдлүүдийг сургуулийн зохих бичиг баримтад заавал хавсаргана. Шагнал болон өөр нэгэн урамшуулга нь гардуулсан байдалтайгаа сургуулийн тайландаа хадгалан бичигдэнэ.
- g) Хэрэв сурагч хичээлийн хагас жилийн эцэст дүгнэгдэх боломжгүй бол сургуулийн тэргүүлэх багш нэмэлтээр дахин дүгнэх огноог тодорхойлж, хагас жилийн дүнг дараагийн хичээлийн жилийн 9-р сарын эцсээр тодорхойлж, дүгнэлтийг заасан хугацаанд гаргахаар төлөвлөнө. 9-р сард дүн гарах хүртэл тус сурагч дараагийн жилийн сургалтад оролцох эсвэл тус есдүгээр жилээ дахин давтана.
- h) Сурагч хичээлийн хоёрдугаар хагас жилийн эцэст сургуулийн хөтөлбөрт заасан хичээлүүдийн сэдвийг сурж эзэмшиж үед дараагийнхаа хичээлийн жил рүү шилжинэ. Үүнд тусгай боловсролын хөтөлбөрт заасан боловсролын хичээлүүд орохгүй ба Боловсролын Актын гуравдугаар бичвэр болох 52 (6)-р Хэсгийн дагуу, хэрвээ тэр дахин хичээлийн жилийг давтах зөвшөөрөлгүй тохиолдолд, түүний чөлөөлөгдсөн хичээлүүд үүнд хамрахгүй. Бага сургуулийн нэгдүгээр ангийн хүүхэд, хэрвээ тэр нэгдүгээр ангийн жилээ дахин давтсан ба бага сургуулийн хоёрдугаар ангийн сурагч хоёрдугаар ангия дахин давтсан үед дараагийн анги руу түүний дүнг харгалзахгүйгээр шилжүүлнэ.
- i) Хэрэв сурагчийн хууль ёсны төлөөлөгч нь дүнгийн үнэн зөв эсэхэд эргэлзэж байгаа тохиолдолд тэр дүнгийн жагсаалт авсны дараагаар ажлын 3 хоногийн дотор, гэрчилгээ өгснөөс тоолж ажлын 3 хоногоос хэтрэлгүй хугацаанд тэргүүлэх багшаас түүний дүнг дахин хянахыг шаардах эрхтэй. Хэрэв тэргүүлэх багш нь эсвэл тусгай тохиолдолд сурагчийн ангийн багш нь тус хүсэлтийг орон нутгийн захиргаатай хэлэлцэж хариу хүсэлт гаргаж болно. Аливаа ямар нэгэн өөр байдлаар заагдаагүй бол, сургуулийн тэргүүлэх багш эсвэл орон нутгийн захиргаа нь сурагчийг тусгай комиссты дахин шалгалт авах тушаал гаргаж болох ба давтан шалгалт нь хүүхдийн хууль зүйн төлөөлөгчтэй тохирч хүсэлт гаргасан огнооноос 14 хоногоос хэтрэлгүй тогтоогдох ёстой. Чех улсын Хянан Шалгах Хэлтэс нь сургуулийн тэргүүлэх багшийн өргөдөл эсвэл орон нутгийн захиргааны хүсэлтэд туслалцаа үзүүлэх үүрэгтэй.
- j) Хэрэв хүүхдийн шалгалтын дунд хяналт хийх хүсэлтийг хүүхдийн зан байдал, сахилга батаас хамааралтай эсвэл боловсролын аль нэгэн үйлдлээс хамаарч гаргасан бол сургуулийн тэргүүлэх багш (хэрэв тэргүүлэх багш нь сурагчийн багш эсвэл тохиох этгээд бол орон нутгийн захиргаа хамаарна) нь сурагчийн сурлагын дүнг 30(2) Хэсэгт тодорхойлсон журмын дагуу ажиглан дүгнэх шаардлагатай. Хэрэв энэхүү дүрэм журмыг зөрчсөн байдал мэдэгдсэн тохиолдолд сургуулийн тэргүүлэх багш эсвэл орон нутгийн засаг захиргаа нь дүгнэлтийг солих шаардлагатай; хэрэв

сурагчийн шалгалтын дүн зөрчигдөөгүй бол дүнг хүсэлт гаргаснаас 14 хоногоос илүүгүй хугацаанд үүнийг баталгаажуулсан хариу өгөх шаардлагатай. Чех улсын Сургууль Хянах Хэлтэс нь орон нутгийн захиргаа эсвэл сургуулийн тэргүүлэх багшийн гаргах хүсэлтэд туслалцаа үзүүлэх үүрэгтэй. Сургуулийн тэргүүлэх багш нь хууль зүйн хариуцагчийн хүсэлтийн дагуу болон эмнэлгийн ажилтаны зөвлөгөөний дагуу тус сурагч эрүүл мэндийн шалтгаанаар хичээлийн жилээ дахин давтаж суралцсан эсэхийг үл харгалзаж, хичээлийн жилээ дахин давтаж сурах зөвшөөрлийг олгох ёстой.

3. Сурагчийн өөрийгөө дүгнэх дурмууд ба зарчмууд

- a) Өөрийн үнэлгээ бол сурагчийн хичээлдээ дүгнэлт хийх чухал нэг хэсэг ба сурагчийн өөрөө өөртөө итгэх итгэл олох, дүгнэх чадварыг сайжруулдаг нэг арга барил юм.
- b) Багш нар энэ арга барилыг сурагчийн насыг тооцож, насанд нь тохируулж боловсрол сургалтын үйл ажиллагаанд оруулсан байдаг
- c) Сургалтын үйл ажиллагаанд алдаа гарах бол жирийн нэг үзэгдэл. Багш нар сурагчидтай өөрсдөд нь тохиох алдаануудын талаар ярилцаж, сурагчид зарим бичвэрүүдээ өөрсдөө хянаж засах, сурагчийн ур чадварыг зөвхөн ангилалаар дүгнэдэггүй, харин сурагчийн алдааны анализ хийхийг бас хамтран үйлддэг. Алдаа бол суралцах чухал нэг хэрэгсэл юм.
- d) Өөрийгөө дүгнэх үйл явцад сурагч доорхийг илрүүлэхийг оролдоно:
 - Юу сайн хийж байна;
 - Юу сайн явагдахгүй байгаа ба үүнийг цаашид сайжруулж болох эсэх;
 - Цаашид ямар үйлдэл хийх вэ.
- e) Багш нар сурагч нарт тэдний ур чадвар ба дүнг шинжлэн ярилцахад туслана.
- f) Сурагчдын өөрийгөө дүгнэх чадвар нь ердийн сонгомол дүгнэлтийг орлуулдаггүй /багш дүн тавьж дүгнэх/, гэхдээ сургалтын нэг хэсэг болдог ба дүгнэх үйлдлийг өргөжүүлж, сурагчийн оролцоо идэвхийг сайжруулдаг байна.
- g) Хичээлийн хагас жил дуусахад сурагч доорх салбаруудад өөрийн дүгнэлтийг хийдэг:
 - хариуцлага;
 - сурах идэвх ба хүсэл;
 - өөртөө итгэх итгэл;
 - ангidaа харьцаа холбоо үүсгэх.
- h) Зөвхөн дүн бол суралцах идэвхи ба хүслийн цорын ганц эх үүсвэр биш.

4. Ангилал хэрэглэж хичээлийн дүн ба сахилгын дүн тогтоох зэрэглэл

Сургуулиас зохин байгуулж байгаа арга хэмжээ ба сурагчийн зан байдал сахилгыг доорх байдлаар дүгнэнэ:

- (a) 1 – маш сайн;
- (b) 2 – дунд;

(c) 3 – муу.

- a) Сурагчдын зан байдлын ангилалыг ангийн багш нь уг ангид хичээл заадаг багш нар болон бусад багш нартай хамтран сурган хүмүүжүүлэх зөвлөлийн хурлаар авч хэлэлцдэг. Хэрэв ангийн багш энэхүү үйл ажиллагааг хүлээж аваагүй тохиолдолд бусад багш нар ч сурган хүмүүжүүлүүлэх ажлын зөвлөлд саналаа хэлж болдог. Биеэ авч явах байдал, сахилгын болзoluуд ангилалын үед мөрдөх сахилгын дүрмүүд (Сургуулийн Дүрмүүд) журмуутдай нийцсэн байх шаардлагатай.
- b) Сахилгын ангилал хийхдээ сурагчийн нас, ухаан санаа ба ёс суртахууны өсөлт хөгжлийг тооцно, аливаа нэгэн авсан арга хэмжээ нь үр дүнгүй болсон тохиолдолд л өөр үйлдэл дэмжих нэмэлт арга хэмжээ авна. Сахилгын зэрэглэлийг доорх байдлаар ангилна:

1 – маш сайн: Сурагч сургуулийн дотоод дүрэм журмыг ба бие авч явах сахилгын дүрмийг сайн дагаж мөрддөг. Тэр хааяа жижиг зөрчил гаргадаг. Гэхдээ сурагч боловсролын ба сургалтын арга хэмжээг хүлээн авдаг, ойлгодог ба алдаагаа засах үйлдлүүдийг хийдэг.

2 – дунд: Сурагчийн бие авч явах байдал нь сургуулийн дотоод дүрэм ба сахилгын дүрмийг зөрчих хандлагатай. Сурагч нь дотоод дүрмийг маш ноцтой байдлаар зөрчиж, жижиг бага зэргийн зөрчил байнга үйлдэнэ. Ерөнхийдөө, тэр ангийнхаа багшийн зэмлэлийг хүлээж авдаггүй, зөрчил үйлддэг ба сургалтын үйл ажиллагааг таслах хандлагатай. Тэр өөрийн аюулгүй байдал ба бусдын аюулгүй байдалд эрсдэл учруулах нөхцөл бүрдүүлдэг.

3 – муу: Сургуульдаа сурагчийн бие авч явах байдал нь маш их зөрчилтэй. Тэр Сургуулийн Дүрмийг байнга ноцтой зөрчиж, үүнийг ухамсартайгаар хүлээж авдаггүй, өөртөө буюу бусдын аюулгүй байдалд байнга занал аюул учруулдаг. Тэр сургуулиас зохиож буй арга хэмжээг байнга тасалдаг. Ерөнхийдөө, тэр сургуулийн тэргүүлэх багшийн зэмлэлийг хүлээж авдаггүй, үргэлжлүүлэн зөрчил үйлдэнэ.

5. Сургуулийн дун ба урьдчилсан зэрэглэлийг оруулсан шинж чанарууд

- a) Сургуулийн хөтөлбөрөөр тодорхойлсон сурагчдын хувийн заавал сурх ба сайн дурын хичээлүүдийн дүнг доорх үечлэл шатлалаар тогтоогддог:
 - a. 1 – онц;
 - b. 2 – маш сайн;
 - c. 3 – сайн;
 - d. 4 – дунд;
 - e. 5 – муу.
- b) Энэ шатлалыг хэрэглэж байхдаа сурагчдын сургуулийн сахилга бат ба хичээлийн болон хичээлээс гадуур зохиож байгаа сургуулийн арга хэмжээнд оролцсон байдлын шатлалыг тодорхой зааж дүгнэх ба сурагчийн

хүрсэн зэрэглэлийг сургачийн сургуулийн хөтөлбөрт оруулж, зохих ангилал тогтоох ба түүний боловсролын ба хувийн шинж чанар ба насыг оруулна.

Ангилал нь сургачийн чармайлт зүтгэл ба үүнийг гүйцэтгэхдээ нөлөөлсөн хам шинжийг оруулдаг.

- c) Сургчдыг нэгдүгээр ангид нь дүгнэхдээ шатлалыг төлөөлсөн тоо хэрэглэх, хоёрдугаар ангид догол мөр 1-ийн дор байгаа ворд танилцуулгатай шатлалыг хэрэглэх шаардлагатай.
- d) Ангилах зорилгоор хичээлүүдийг гурван бүлэгт хуваасан:
 - a. Онол голчилсон теорийн хичээлүүд;
 - b. Практик үйл ажиллагаа шаардах хичээлүүд;
 - c. Боловсрол ба урлагийн хичээлүүд.
- e) Хувийн үечлэлийн болзoluуд нийт ангилалд анхдагч байдлаар тайлбарлагдсан байгаа. Гэхдээ багш нь дээр дурьдсан зэрэглэлийн аль нэгэнд нь давуу тал оноож болохгүй ба сургачийн чадвар чармайлтыг хичээлд нь тохируулан ойлголттой хандаж дүгнэнэ.

Онол голчилсон хичээлүүдийн ангилал

Онол голчилсон хичээлүүдэд хэл зүй, нийгмийн шинжлэх ухаан ба байгалийн шинжлэх ухаануудыг хамарсан хичээлүүд болон тоо зэргийн хичээлүүд орно.

Онол голчилсон хичээлүүдийг ангилж байхдаа сургалтын хөтөлбөрийн шаардлагуудтай хамт доорх байдлуудыг дагалдан дүгнэдэг:

- ойлголт, хичээнгүй байдал ба шаардсан мэдлэгийг сурж байхдаа тогтвортой тогтмол байдалтай байх, фактууд, үзэл баримтлалууд, тодорхойлолтууд, хэв маягууд ба харилцаа холбоо, сурсан чадваруудаа хэрэглэхийг шаардсан оюун ухааны ба хөдөлгөөний үйл ажиллагааг сурх чадварын чанар зэрэг орно;
- нийгмийн, байгалийн үзэгдлүүд ба жишгүүдийг тайлбарлах, онол практикийн даалгавруудыг шийдэхдээ олж авсан мэдлэгээ хэрэгжүүлж байгаа чадвар;
- эрэгцүүлэн бodoх чадвар, ялангуяа логик, бие даах байдал ба бүтээн хийх чадварууд;
- арга хэмжээнд оролцох сонирхол ба оролцож байгаа байдал;
- нягт нямбай байдал, нарийвчлах чадвар ба амаар болон бичгээр илэрхийлэх мэргэжлийн ба хэл зүйн зөв байдал;
- арга хэмжээ, үйл ажиллагааны үр дүнгийн чанар;
- бие даасан сурлагын үр дүнтэй арга барилд суралцах.

Сургалтын дүгнэлт доорх зэрэглэлийн дагуу ангилагдана:

1 – онц сайн

Сургач шаардсан мэдлэг, фактууд, томъёо, тодорхойлолтууд ба дүрмүүдийг сайн ойлгосон, нягт нямбай ба бүрэн бүтэн байдлаар хичээлийг үйлдсэн ба хоорондын холбоог сайн ойлгож байгаа. Тэр шаардсан оюун ухааны ба үйлдлийн үйл ажиллагааг маш хурдан гүйцэтгэдэг. Тэр олж авсан мэдлэгүүд ба үр чадвараа бие даасан байдлаар болон бүтээлчээр онол практикийн даалгавар хийхдээ хэрэгжүүлдэг. Тэр логик сайтай ба зөв бодож тунгааж байгаа бөгөөд бие даасан байдалтай, өөртөө итгэлтэй. Түүний амаар ба бичгээр үйлдэх ажиллагаа ба бичлэгүүд маш нямбай ба зохицтой. График байдлаар дүрслэхдээ нямбай ханддаг ба гоо сайхны мэдрэмжтэй. Түүний ажлын үр дүн нь чанартай байдаг ба зөвхөн маш жижиг дутаглууд ажиглагддаг. Тэр өөрт оноосон бичвэрүүдийг бие даан судлах чадвартай.

2 – маш сайн

Сурагч шаардсан мэдлэг, фактууд, томъёо, тодорхойлолтууд ба дүрмүүдийг ойлгоцтой, нягт нямбай ба бүрэн бүтэн байдлаар сурдаг ба хоорондын холбоог ойлгодог. Тэр шаардсан оюун ухааны ба үйлдлийн үйл ажиллагааг маш хурдан гүйцэтгэдэг. Тэр бие даасан байдалтай ба бүтээлчээр олж авсан мэдлэгүүд, ур чадвараа онол ба практикийн даалгавар хийхдээ хэрэгжүүлдэг. Тэр логик сайтай, зөв бодож тунгаадаг ба бие даасан байдалтай. Тэр зөв бодолтой, логик сайтай ба уран бүтээлчээр сэтгэдэг. Амаар ба бичгээр үйлдсэн даалгавруудын нямбай нухацтай, зөв хийдэг ба заримдаа бага зэргийн дутагдал гаргадаг. Зохиогдох арга хэмжээний оролцоо ерөнхийдөө онцлох том зөрчилгүй явагддаг. График байдлаар дүрслэх чадвар сайн, нямбай ба том алдаа гаргадаггүй. Түүний үйл ажиллагааны үр дүн нь чанартай ба зөвхөн маш жижиг дутагдлууд харагдана. Тэр бичвэрүүдийг бага зэргийн туслалцаа авж бие даан судлах чадвартай.

3 – сайн

Сурагчийн ойлгох чадвар сайн, нямбай байдалтай ба тэр зохих мэдлэг хүлээж авах, фактууд, томъёо, тодорхойлолтууд ба дүрмүүдийг ойлгодог, нягт нямбай ба бүрэн бүтэн байдлаар үйлддэг, гэхдээ зүйл хоорондын холбоог цаашид үргэлжлүүлэн сурах шаардлагатай. Оюун ухааны эсвэл хөдөлгөөний үйл ажиллагаа хийж байхдаа түүнд зарим дутагдлууд илэрдэг. Тэр заримдаа мэдэгдэхүйц, буруу няхуургүй үйлдлүүд хийдэг ба алдаагаа багшийн тусламжтайгаар бүрэн засах чадвартай. Олж авсан мэдлэгүүдээ хэрэгжүүлдэг ба багшийнхаа тусламжтай үзэгдлүүд ба дүрмүүдийг сурж хэрэгжүүлдэг. Түүний бодлын явц зөв, гэхдээ бүтээлч биш, түүний логик бодолд алдаа гарч ирдэг. Түүний зөв байдал, нямбай чанар ба амаар буюу бичгээр илэрхийлэх чадварт зарим дутагдлууд бий. Түүний үйл ажиллагааны дүн ба чанар нь зарим зүйлийг дутаасан байдалтай, графикаар үзүүлэх чадвар нь гоо сайхны мэдрэмж муутай ба бага зэргийн дутагдалтай. Тэр багшийн туслалцаатай бие дааж хичээллэх чадвартай.

4 – дунд

Сурагч ойлгох чадвартай, нягт нямбай ба шаардсан мэдлэг олох ба хичээлийг сурах чадвар өөрт нь бий. Шаардсан оюун ухааны ба хөдөлгөөний үйл ажиллагаа хийж байхдаа тэр хурдан шаламгай биш ба зарим дутагдлууд илэрнэ. Олж авсан ба сурсан мэдлэг чадварыг онол практикт хэрэгжүүлэхдээ тэр ноцтой алдаа гаргадаг. Үзэгдлийг тайлбарлах ба дүгнэхдээ, өөрийн мэдлэгүүдийг оролцуулахдаа тэр бие дааж чаддаггүй. Логик сэтгэхүй нь маш замбараагүй ба тэр бусдаас их хамааралтай, түүний бодол уран бүтээлч биш. Түүний амаар болон бичгээр илэрхийлэх чадвар дутагдалтай ба алдаатай, нямбай биш ба хоорондоо зохицолгүй. Түүний график үзүүлэлт гаргах ба арга хэмжээнд оролцох байдалд дутагдалтай, график үзүүлбэр нь мэдрэмжгүй. Сурагч багшийнхаа тусламжтайгаар өөрийн ноцтой дутагдлуудыг цаашид засах чадвартай.Өөрөө бие дааж суралцахдаа маш их хүндрэлтэй.

5 – муу

Сурагч нь шаардсан мэдлэг олж авдаггүй, хичээлээ ойлгодоггүй ба тодорхой болон бүрэн бүтэн сурдаггүй, түүнд маш их алдаа бий. Түүний оюун ухаан ба хөдөлгөөний үйл ажиллагааны хийх чадвар маш их дутагдалтай ба хийсэн ажлын үр дүн муу. Онол практикийн шаардсан мэдлэг олж авах, сурахдаа тэр маш их ноцтой алдаа гаргадаг. Үзэгдлүүд ба дүрэм журмийг тайлбарлахдаа тэр багшийн тусламж авсан мөртлөө үүнийг хэрэгжүүлж чаддаггүй. Түүний бодолд биөэ

даасан байдал байдаггүй, логик сэтгэмж маш муюу. Тэр нямбай биш, цэгцгүй, ажиллагаа хийхдээ маш их дутагдалтай хийнэ, ажлаа бичгээр ба амаар илэрхийлэхдээ маш муюу. График үзүүлбэрийн ажлын чанар маш муюу ба ноцтой алдаа ихтэй. Түүнд багш нь тусалсан ч гэсэн тэр дутагдлуудаа засах чадваргүй. Тэр бие дааж суралцаж чаддаггүй.

Практик тал давангуйлсан хичээлийн ангилал

Бага сургуулиудад үйл ажиллагааны гол практикийн чиглэл бол байгалийн шинжлэх ухааны хичээлүүд ба мэдээллийн технологийн хэрэгжүүлэлт байдаг. Хичээлүүдийг практик чиглэлээр ангилахад сургалтын хөтөлбөрийн дагуу шаардлагуудын дагуу доорх байдлуудыг мөн адил дүгнэдэг:

- ажилд хандах хандлага, багаар хамтран ажиллах ба практикийн арга хэмжээнүүд;
- практик чадвар ба зуршил олж авах, ажил гүйцэтгэх хамгийн үр дүнтэй замыг олох;
- сурсан онолын мэдлэгээ практик үйл ажиллагаанд нэвтрүүлэх чадвар;
- үйл ажиллагаа, бие даах чадвар, уран бүтээлч чанар, практик үйл ажиллагаанд санаачлага гаргах;
- үйл ажиллагааны үр дүнгийн чанар;
- ажил ба ажлын байраа зохион байгуулах, ажлынхаа байранд эмх цэгцтэй ажиллаж сурх;
- ажилдаа эрүүл ахуй ба аюулгүй байдлын дүрмийг дагах ба орчныг хамгаалах;
- материалууд, эрчим хүч, ажлын саад бэрхшээлийг даван туулах, түүхий эдийн хэмнэлттэй хэрэглээ;
- лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тусламж ба хэмжүүрүүдтэй ажиллах үйлдэлүүд ба засвар үйлчилгээ.

Сургалтын дүнг доорх шатлалын дагуу ангилсан болно:

1 – онц

Сурагч байнга өөрийн ажиллах чадвар, багаар ажиллах чадвар ба практикийн идэвхтэй үйл ажиллагаагаа эерэг талаас харуулж байдаг. Тэр практик үйл ажиллагаандаа онолыг байнга хэрэгжүүлж, бие даах чадвартай ба уран бүтээлч хандлагатай. Тэр практик арга хэмжээг зөв цэгцтэй, бие дааж гүйцэтгэдэг ба сурсан хичээлээ ба чадвараа үүнд оролцуулдаг. Тэр ажлын арга барил ба дүрэм журмыг мөрддөг, тэр маш бага алдаа гаргадаг, түүний ажлын үр дүн нь онцлох том дутагдалгүй байдаг. Тэр өөрт ноогдсон ажлыг үр дүнтэй зохион байгуулдаг, ажлын орон байраа цэвэр нямбай байлгана. Тэр эрүүл мэнд ба аюулгүй байдлын зааврыг мөрддөг ба түүний ажиллагаа нь орчин тойрныг хамгаалах зохион байгуулалттай. Тэр түүхий эд, материалууд ба эрчим хүчийг хэмнэдэг. Тэр лабораторийн тоног төхөөрөмж, багажууд ба хэмжүүрүүдтэй үлгэр жишээч байдлаар харьцаж ажилладаг. Тэр өмнө нь тулгарсан саад бэрхшээлийг идэвхтэй давж гардаг.

2 – маш сайн

Сурагч үйл ажиллагаа, багаар ажиллах хамтран ажиллагаа ба практик үйл ажилд ухамсартай ба эерэгээр ханддаг. Тэр практик үйл ажиллагаандаа онолыг байнга хэрэгжүүлж, бие даах чадвартай, гэхдээ арай бага уран бүтээлч чадвартай ба өөртөө итгэлгүй хандана. Тэр практик үйл ажиллагаанд хувийн үүднээс ханддаг,

түүний арга барил ба ажилд том алдаа гарагчий. Түүний ажлын үнэлгээнд маш бага алдаа дутагдал харагддаг. Тэр өөрт ноогдсон ажлыг үр дүнтэй зохион байгуулдаг, ажлын орон байраа цэвэр нямбай байлгана. Тэр эрүүл мэнд ба аюулгүй байдлын зааврыг даган мөрддөг ба түүний ажиллагаа нь орчин тойрныг хамгаалах зохион байгуулалттай. Тэр түүхий эд, материалууд ба эрчим хүчийг хэмнэдэг. Тэр лабораторийн тоног төхөөрөмж, багажууд ба хэмжүүрүүдтэй үлгэр жишээч байдлаар харьцаж ажилладаг. Тэр өмнө нь тулгарсан саад бэрхшээлийг багшийнхаа тусlamжтай идэвхтэй давж гардаг.

3 –сайн

Сурагч ажиллагаа, багаар хамтран ажиллах ажиллагаа ба практик үйл ажиллагаанд ухамсартай гэхдээ бага зэрэг алдаа гаргаж ханддаг. Багшийнхаа тусlamжтайгаар тэр өөрийн онолын мэдлэгээ практикт хэрэгжүүлдэг. Практик үйл ажиллагаандаа тэр алдаа гаргадаг ба арга барил нь багшийн тусlamцаа авахыг шаарддаг. Ажлын үнэлгээнээс харахад ажлаа дутуу хийж байгаа нь илэрнэ. Тэр өөрийн ажлаа зохион байгуулахдаа шаламгай биш, гэхдээ ажлынхаа орчныг цэвэр цэмцгэр байлгадаг. Тэр аюулгүй байдлын дүрэм ба эрүүл мэндийн нөхцөлд ажлаа нийцүүлж чаддаг, байгаль орчноо хамгаалах чадвартай. Багшийн тусlamж ба зааварчилгааны дор тэр түүхий эд, материалууд ба эрчим хүч хэмнэх чадалтай. Тэр лабораторийн тоног төхөөрөмж, багажууд ба хэмжүүрүүдтэй хагасчлан ажиллах чадвартай. Тэр өмнөө тулгарсан саад бэрхшээлийг багшийнхаа тусlamжтай давж гардаг.

4 – дунд

Сурагч ажиллагааны үед, ажлын баг ба практик үйл ажиллагаандаа ямар ч сонирхолгүй ажиллах хандлагатай. Тэр онолын мэдлэгээ практик ажилдаа зөвхөн багшийнхаа тусlamжтай хэрэгжүүлж чаддаг. Практик үйл ажиллагаа, ур чадвар зэрэгт тэр том алдаа гаргадаг. Ажлын арга барил журмыг сонгохдоо тэр байнга багшаасаа тусlamж авдаг. Түүний ажлын үр дүн нь ноцтой дутагдуудтай. Тэр ажлаа багшийнхаа байнгын тусlamжтай ба зөвхөн түүнтэй хамт зохион байгуулдаг, тэр ажлын орчноо ямагт цэвэр нямбай байлгаж чаддаггүй. Тэр аюулгүй байдлын дүрэм ба эрүүл мэндийн нөхцөлд ажлаа нийцүүлж чадах нь ховор, байгаль орчноо хамгаалах ухамсар чадвар мую. Тэр түүхий эд, материалууд ба эрчим хүч хэмнэх журмыг мөрдөж чаддаггүй. Тэр лабораторийн тоног төхөөрөмж, багажууд ба хэмжүүрүүдтэй хагасчлан ажиллахдаа ноцтой зөрчил гаргадаг. Тэр өмнө нь тулгарсан саад бэрхшээлийг зөвхөн багшийнхаа тусlamжтай давж гардаг.

5 – муу

Сурагч нь ажиллагаа, багийн хамтарсан ажиллагаа ба практик үйл ажиллагаанд огт сонирхолгүй. Багш тусалсан ч гэсэн тэр онолын мэдлэгээ практикт хэрэгжүүлэх чадваргүй. Практик үйл ажиллагаандаа тэр маш их дутагдал зөрчил гаргадаг. Тэр багш тусалсан ч гэсэн заасан ажлыг хийж чаддаггүй. Тэр ажлаа үр дүнтэй төгсгөж чаддаггүй, ажил нь ямагт дуусаагүй, замбараагүй ба заасан нөхцлүүдэд тохироогүй байдалтай. Тэр ажлын заасан хэсэгт ажлаа зохион байгуулах чадваргүй, ажлын байр нь цэвэр цэмцгэр биш. Тэр түүхий эд, материалууд ба эрчим хүч хэмнэж чаддаггүй. Байгаль орчинг хүндэлж хамгаалж

чаддаггүй. Тэр лабораторийн тоног төхөөрөмж, багажууд ба хэмжүүрүүдтэй ажиллахдаа ноцтой зөрчил гаргадаг ба үүнтэй харьцаж чаддаггүй.

Сургах тал давамгайлсан хичээлүүдийн ангилал

Доорх хичээлүүдэд боловсролын тал давамгайлсан: үүнд, урлаг соёлын сургалт, дуу хөгжим, спорт бие бялдар хөгжүүлэх сургалт, спортын тоглоомууд, экологи ба хэвлэл мэдээлэл медиа сургалт зэрэг орно.

Хэрэв эмчийн заалттай бол тусгай спорт бие бялдарын сургалтанд хамрах сургач эрүүл мэндийн хяналт шалгуурт орох ёстой.

Боловсролын тал давамгайлсан хичээлүүдийг ангилахдаа сургуулийн хөтөлбөрийн доорх шаардлагуудтай тохируулах шаардлагатай:

- уран бүтээлч байдлын түвшин ба илэрхийлэлдээ биеэ даасан байдал;
- зайлшгүй хэрэгцээтэй мэдлэг, туршлага, үйл ажиллагаа ба түүний уран бүтээлч хэрэглээг эзэмшсэн байх;
- өөрийн үйл ажиллагаанд хамаарах дүрэм журмын мэдлэг ба түүнийг хэрэгжүүлэх тухай мэдлэгтэй байх;
- үг ярианы чадвар;
- сургачийн уг үйл ажиллагаанд хандуулах анхаарал ба сонирхол;
- гоо сайхны мэдрэмж, урлагийн ажилд оролцох чадвар ба нийгэмд эзлэх гоо сайхны мэдрэмж;
- спорт боловсролд сургачийн эрүүл мэндийг харгалзаж өөрийн эрүүл мэндэд анхаарал тавих чадвар, бие бялдар, биеийн хүч чадвар зэрэг орно.

Хичээлийн дүн нь доорх зэрэглэлээр тоологдож ангилна:

1 – онц

Сургаг хичээлдээ маш их идэвхтэй. Тэр уран бүтээлч хандлагатай, бие дааж ажилладаг, өөрийнхөө ур чадварыг бүгдийг ашиглаж чаддаг, өөрийн чадвараа маш их амжилттайгаар сургуулийн хөтөлбөрийн шаардлагын дагуу ганцаарчилсан болон олон нийтийн ажилд нэвтрүүлэн оруулж чаддаг. Түүний илэрхийлэл бол гоо сайхны гүн мэдрэмжтэй, өвөрмөц, гүнзгий мэдрэмжтэй, дуу хөгжим ба бие бялдрын боловсролд сайн гаралтай, маш их няхуур нямбай. Тэр өөрийн олж авсан мэдлэгээ уран бүтээлчээр хэрэгжүүлдэг. Тэр урлаг, гоо сайхан ба биеийн тамирт маш их сонирхолтой ба үүгээр идэвхтэй хичээллэдэг. Тэр гоо сайхны мэдрэмжээ амжилттай хөгжүүлдэг ба биеийн тамирт гаралтай.

2 – маш сайн

Сургаг идэвх зүтгэлтэй, өөрийн ур чадвараа ашиглахдаа бие даасан байдалтай, үүнийгээ хувийн ба олон нийтийн нөхцөлд сайн илэрхийлж гаргадаг. Түүний илэрхийлэл нь гоо сайхны мэдрэмжтэй ба сургуулийн зохих хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд маш бага алдаа дутагдал гаргадаг. Сургаг олж авсан зохих мэдлэгийг шинэ даалгавар асуудал шийдэхдээ уран бүтээлчээр хэрэгжүүлдэг. Тэр урлаг, гоо сайхан ба биеийн тамир голцуу сонирхдог. Тэр гоо сайхан, бие бялдаржуулалт ба фитнесд зохих шатлалын оноо олж авч чаддаг.

3 – сайн

Сургачийн идэвх чармайлт арай сул, тэр арай бага бие даасан байдалтай, уран бүтээлч ба хурдан ажилладаг. Тэр ганцаарчилсан ба олон нийтийн хичээлд өөрийнхөө ур чадварыг бүрэн бүтэн гаргадаггүй. Түүний илэрхийлэл сэтгэл хөдөлгөм биш, тэр алдаа гаргадаг. Түүний мэдлэг ба ур чадварыг сайжруулах

хэрэгтэй ба түүнд үүнийг хийхэд багшийн туслалцаа шаардагдана. Тэр урлаг, гоо сайхан ба биеийн тамир нэг их сонирходоггүй ба идэвхгүй. Тэр зохих шатны шаардагдсан гоо сайхны мэдрэмжгүй ба спортын оролдлого муу.

4 – дунд

Сурагч маш идэвхгүй ба уран бүтээлч биш. Түүний ур чадвар ба түүний илэрхийлэл дутмаг байдалтай. Тэр хичээл даалгавар хийхдээ их алдаа гаргадаг. Тэр олсон мэдлэг ба ур чадвараа зөвхөн багшийнхаа тусламжтай хэрэгжүүлж чадна. Тэр хичээл, үйл ажиллагаандын сонирхолгүй, гоо сайхны мэдрэмж ба биеийн тамир зэрэгт идэвхгүй.

5 – муу

Сурагч үйл ажиллагаанд огт оролцдоггүй. Түүний ур чадварын хөгжил маш муу. Түүний илэрхийлэх чадвар буруу ба гоо сайхны мэдрэмжгүй. Тэр өөрийн олж авсан мэдлэгийн бага хэсгийг ч хэрэгжүүлж чаддаггүй ба ур чадваргүй. Тэр үйлдэж буй ажилдаа сонирхолгүй ханддаг ба гоо сайхны мэдрэмж болон спортын мэдлэг олж авахыг чармайж хичээдээгүй.

Сурагчийн шалгалт дүгнэлтийн тайлан доорх байдлаар хийгддэг:

- (a) онц амжилт үзүүлсэн;
- (b) амжилттай;
- (c) амжилтгүй;
- (d) дүгнэгдээгүй.

Сурагчийг доорх маягаар дүгнэнэ:

- (a) онц амжилт үзүүлсэн –хэрэв сургуулийн тайлагнаалд сургуулийн хөтөлбөрт орсон зайлшгүй үзэх хичээлүүдийн аль нь 2- маш сайнаас доош дүн үзүүлээгүй тохиолдолд ба түүний ерөнхий дунд дүн нь 1.5 –аас дээшгүй тохиолдол, түүний сахилга бат маш сайн байх тохиолдол орно;
- (b) амжилттай – хэрэв сургуулийн тайлагнаалд сургуулийн хөтөлбөрт орсон зайлшгүй үзэх хичээлүүдийн аль нь 4 - дунд гэх дүгнэлтээс доошгүй дүгнэсэн эсвэл үүнтэй адил амаар дүгнэсэн дүгнэлттэй байсан тохиолдол орно;
- (c) амжилтгүй - хэрэв сургуулийн тайлагнаалд сургуулийн хөтөлбөрт орсон зайлшгүй үзэх хичээлүүдийн аль нэг нь 5- муу гэх дүгнэлтээр дүгнэгсэн, эсвэл тэр жилийн хоёрдугаар хагасанд аль нэгэн хичээлд дүгнэгдээгүй тохиолдол орно.
- (d) хэрэв сурагч хичээлийн жилийн нэгдүгээр хагаст хугацаанд сургуулийн тайлагнаалд сургуулийн хөтөлбөрт орсон зайлшгүй үзэх хичээлүүдийн дүгнэлт хийх боломжгүй болсон тохиолдол орно.

Чех улсын иргэншилгүй ба Чех улсын ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа сурагчдыг дүгнэхдээ сурагчийн сургалтад чех хэлний мэдлэг маш том орон зайдэг гэж үздэг. Ийм сурагчдын “Чех хэл ба чех уран зохиол” хичээлийг дүгнэж байхад Бага Сургуулийн Боловсролын хүрээнд Чех улсад сургуульд орсноос хойш чех хэл эзэмшсэн байдал гол шалгуур болдог ба хичээлийн гурван хагас жилийн эцэст энэ нь хүүхдийн чадвар ур чадварт байнгын ноцтой их нөлөө үзүүлдэг гэж үздэг.

6. Комисс ба дахин хянах шалгалтын нарийвчлалууд

- a) 9-р ангийн сурагчид ба бага сургуульдаа дахин хичээлийн жилээ улиран давтаагүй, гэхдээ хичээлийн жилийн хоёрдугаар хагасад зайлшгүй сурх хичээлдээ тэнцээгүй унасан сурагч нар заавал дахин хянах шалгалтыг давтан өгөх шаардлагатай. Үүнд боловсролын хандлагатай хичээлүүд орохгүй.
- b) Дахин хянах шалгалтуудыг хичээлийн жилийн эцэст сургуулийн тэргүүлэх багшийн тодорхойлсон огноод дахин тогтоох ёстой. Сурагч нь нэг өдөр зөвхөн нэг дахин хянах шалгалт өгөх эрхтэй. Дахин хянах шалгалт нь тусгай томилсон комиссийн өмнө явагддаг.
- c) Дахин хянах шалгалтанд тэнцээгүй сурагчийг эсвэл хүрэлцэн ирээгүй сурагчийг шалгалтандаа тэнцээгүй гэж үздэг. Зарим ноцтой шалтгаан заасан тохиолдлуудад сургуулийн тэргүүлэх багш дахин хянах шалгалтын нэмэлт огноог дараачийн хичээлийн жилийн 9-р сарын 15-нд тогтоох эрхтэй. Тэр хүртлээ сурагч нь дараачийн ангид орсон гэж тооцно, үгүй бол дахин 9-р ангид орсон гэж тооцно.
- d) Зарим шалтгаантай тохиолдлуудад орон нутгийн захиргаа дахин хянах шалгалт ба дахин хянах шалгалтын комиссийг өөр нэгэн сургуулиар хийлгэх шийдвэр гаргах эрхтэй. Орон нутгийн захиргааны хүсэлтээр шалгалтыг сургуулийн хянагч хянаж шалгах эрхтэй.

7. Бага сургуулийн дахин шалгах комисс ба хянах шалгалтуудын хоорондын ялгаа

- a) Дахин шалгах комисс нь сургуулийн тэргүүлэх багшаар тодорхойлогддог, сургуулийн тэргүүлэх багш нь тус хичээлийн багш байгаа тохиолдолд комисс нь орон нутгийн захиргааны албаар тогтоогдож болно.
- b) Комисс гурван гишүүний бүрэлдэхүүнтэй:

Дарга, тэр нь сургуулийн тэргүүлэх багш эсвэл сургуулийн тэргүүлэх багшаар томилогдсон багш байж болно, эсвэл хэрэв сургуулийн тэргүүлэх багш нь хичээлийн багш бол орон нутгийн захиргааны албаас томилогдсон өөр нэгэн сурган хүмүүжүүлэх ажилтан байж болно;

Хянагч багш, тэр нь сурагчийн зохих ангийн хичээлийн багш, эсвэл өөр нэгэн энэхүү хичээл заадаг багш байж болно;

Дүгнэгч багш, тэр нь энэхүү хичээлийн өөр нэгэн багш эсвэл Бага Сургуулийн Боловсролын Хөтөлбөрийн хүрээнд томилогдсон тус хичээлийн сэдвийг заадаг өөр нэг багш байж болно.

- c) Дахин хянах шалгалтын дүн нь шалгалтыг дахин хийлгэх хүсэлт гаргаж маргааны шалтгаан болох ёсгүй. Дахин хянах шалгалтын дүн нь Комиссийн сонгуулиар тодорхойлогдоно. Дахин хянах шалгалтын дүн нь нь зэрэглэлээр эсвэл амаар авсан шалгалтаар дүгнэгдэнэ. Сургуулийн тэргүүлэх багш нь дүнг сурагчид эсвэл түүний хууль зүйн төлөөлөгчид хэлж ярих байдлаар танилцуулж болно. Зэрэглэл өөрчлөгдсөн тохиолдолд

хичээлийн нэгдүгээр эсвэл хоёрдугаар хагас жилийн эцэст сурагчид сурлагын шинэ тайланг танилцуулна.

- d) Дахин хянан шалгалтын үеэр сургуулийн бичиг баримтын нэг хэсэг болох бичлэг хийнэ.
- e) Сурагчдад нэг өдөр зөвхөн нэг хичээлийн шалгалт өгөхийг зөвшөөрнө. Хэрэв сурагч маш ноцтой шалтгаанаар дахин шалгалт өгөх боломжгүй бол комиссийн гишүүн дахин шалгалтын огноог тодорхойлно.
- f) Сургуулийн тэргүүлэх багш сургуулийн хөтөлбөрийн дагуу тусгай агуулга ба дахин шалгах сэдвийн хэмжээг тодорхойлно.
- g) Давтан өгөх шалгалт нь шалгалтыг зөв явуулах боломжийг олгож явагдана.

8. Гадаад дахь сургуулийн шалгалтууд

Гадаадад ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа ба нөхөн давтах сургуульд шалгалт өгж байгаа сурагч доорх мэдээллийг анхааралдаа авах ёстой:

- a) Бага Сургуулийн Боловсролын Хөтөлбөрийн хүрээнд заагдах “Чех хэл чех ба уран зохиол” боловсролын хэсэг болох боловсролын агуулгыг жил бүр авч байх;
- b) Чех улсын түүх ба газар зүйн хичээлийн анхан шатны агуулгыг сүүлчийн хоёр жилд Бага Сургуулийн Боловсролын Хөтөлбөрийн хүрээнд өгөгдөх “Хүн ба түүний ертөнц” гэх боловсролын хэсгээс сурах,
- c) Чех улсын түүх ба газар зүйн хичээлийн агуулгыг хоёрдугаар шатны сүүлчийн хоёр жилд Бага Сургуулийн Боловсролын Хөтөлбөрийн хүрээнд өгөгдөх “Түүх” гэх боловсролын хэсгээс сурх ба Чех улсын түүх ба газар зүйн хичээлийн анхны шатны агуулгыг сүүлчийн хоёр жилд Бага Сургуулийн Боловсролын Хөтөлбөрийн хүрээнд өгөгдөх “Газар зүй” боловсролын хэсгээс сурах.
- d) Гадаад буй сурагч нь хувийн сургалт хэлбэрээр сургуульд явж байгаа тохиолдолд шалгалт авах сургуулийн хөтөлбөрөөр тодорхойлогдсон хичээл бүрт шалгалт өгөх шаардлагатай.
- e) Шалгалтын агуулга нь бол догол мөр 1 эсвэл догол мөр 2-ын дагуу сургуульд орж суралцасны дараах хугацааны боловсрол сургалтын агуулга болно. Тусгай агуулга ба шалгалтын хүрээ нь шалгалт авах сургуулийн тэргүүлэх багшаар тодорхойлогдох ёстой бөгөөд шалгалт авах сургуулийн хөтөлбөрийн дагуу явагдана. Тэргүүлэх багш нь тодорхойлогдсон агуулга ба шалгалтын материалтайгаа шалгалтын өмнө сурагчийн хууль зүйн төлөөлөгчтэй уулзана.
- f) Шалгалт нь сургуулийн хичээлийн жилийн эцсийн хагас жилд явагдах ба хоёр хичээлийн жилээс илүү хэтэрч болохгүй.
- g) Шалгалтыг тусгай комисс авна. Комисс нь тэргүүлэх багшаар тодорхойлогдоно.
- h) Комисс гурван гишүүнээс бүрдэнэ:

- *Дарга*, тэр нь шалгалт авч байгаа сургуулийн тэргүүлэх багш эсвэл тэргүүлэх багшаар заасан өөр нэгэн багш;
 - *Шалгалт авах багш*, тэр нь шалгалт авч буй хичээлийн ангийн багш, эсвэл уг хичээлийн сэдвийг хариуцсан өөр нэгэн багш;
 - *Дүгнэгч багш*, тэр нь энэ хичээлийн сэдвийг хариуцах өөр багш эсвэл Бага Сургуулийн Боловсролын Хөтөлбөрөөр тодорхойлсон адил боловсролын сэдвийн эрхлэгч байж болно.
- i) Шалгалтын огноог шалгалт авах сургуулийн тэргүүлэх багш сурагчийн хууль ёсны төлөөлөгчтэй хамтран шалгалт авсан хугацаанаас хоёр сарын хугацаанд дахин шалгалт авах болзoltой зөвшилцдэг. Сурагчийн хууль ёсны төлөөлөгч ба шалгалт авах сургуулийн тэргүүлэх багшийн хооронд зөвшилцэл байхгүй тохиолдолд шалгалт авах сургуулийн тэргүүлэх багш өөрөө шалгалтын огноог тогтооно. Хэрвээ сурагч товлосон хугацаанд шалгалт өгөхгүй байх ноцтой шалтгаантай болсон тохиолдолд шалгалт авах сургуулийн тэргүүлэх багш нь шалгалт авснаас дөрвөн сараас хэтрэлгүй хугацаанд давтан орлох шалгалт авах өөр нэгэн огноог өөрөө тодорхойлох ёстой.
- j) Шалгалтын өмнө сурагчийн хууль ёсны төлөөлөгч шалгалт авах сургуулийн тэргүүлэх багшид гадаадын сургуулийн хичээлийн жилийн тайлагнал, мөн үүний чех хэл рүү хөрвүүлсэн материалыудыг хүлээлгэж өгөх ёстой. Хэрэв сургуулийн тайлагналд сурагч хичээлийн жилээ амжилттай дүүргэсэн эсэхийг тэмдэглээгүй бол сурагчийн хууль ёсны төлөөлөгч нь тус гадаадын сургуулиас тус хичээлийн жилээ амжилттай дүүргэсэн эсвэл тэр хичээлийн жилийг амжилтгүй суралцсан гэх баримт болон түүний чех хэл рүү орчуулсан материалыудыг хүлээлгэж өгөх шаардлагатай. 9-р хичээлийн жилийн эцэст сурагчийн дүнг тодорхойлоход гадаад сургуулиас гаргасан сурагчийн 9-р хичээлийн жилээ амжилттай дүүргэсэн шалгалтуудын дүн нь маш чухал байр эзэнтэй. Орчуулгыг нямбай цэгц хийсэн эсэхэд эргэлзээ гарвал шалгалт авах сургуулийн захирал нь албан ёсны баталгаажуулсан орчуулгыг шаардах эрхтэй.
- Шалгалтын үед сургуулийн баримт бичгийн хэсэг болох бичлэг хийгдэнэ.
- k) Шалгалтын дүн нь Комиссоор тусгай санал өгөх байдлаар тогтоогдоно. Шалгалтын дүн нь зэрэглэл эсвэл амаар авах дүгнэлтээр тогтоогдоно. Шалгалт авсан сургуулийн тэргүүлэх багш сурагч ба түүний хууль зүйн төлөөлөгчид шалгалтын дүнг харуулах боломжтой бүх байдлаар гардуулан өгнө. Шалгалт өгсний дараа шалгалт авч байгаа сургуулийн захирал сургуулийн тайлагналын сурагчид гардуулна. Сургуулийн тайлагналд сурагчийн сахилга зан байдлыг дүгнээгүй байна. Тайлагнал нь “Žák(унě) plní povinnou školní docházku podle § 38 školského zákona” (Сурагч нь Боловсролын Актын 38-р Хэсгийн дагуу ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа болно) гэх бичвэрийг агуулсан байх шаардлагатай.
- l) Хэрэв сурагчийн хууль ёсны төлөөлөгч нь шалгалтын дунгийн талаар ямар нэгэн санал гомдолтой байна гэж үзвэл тэр дахин шалгалт авахыг шаардах эрхтэй.

9. Дүгнэлтийн баримт бичиг олгох арга барил

- a) Ангилалын хураангуйг гаргахдаа багш нь сурагчийн нас ба аливаа нэгэн өөр тодорхойлолтыг харгалзах ба ангилалын хугацаанд зохих хэмжээний мэдлэг боловсрол олж туршлагатай болсон байдлыг мөн адил харгалзана.
- b) Сурган хүмүүжүүлэх ажилтнууд сурагчийн хичээлийн дүн, түүний боловсролын нийт дүн болон сурагчийн сахилгыг тодорхойлохдоо ойлгомжтой, цэгц, урьд тодорхойлогдсон байдал ба зэрэглэлд тохирсон, бодитой, уян хатан, сурган хүмүүжүүлэгчийн арга барилаар тогтоогдсон, мэргэжлийн ба харагдахуйц байдлаар гаргана.
- c) Багш нар дүгнэх ба ангилах өгөгдөлүүдийг доорх арга барилаар хийнэ: сурагчдыг байнга ажиглаж тодорхойлох, ангидаа тэдний бэлэн байх байдал болон тэдний чармайлтыг тэмдэглэж хянах, олон төрлийн шалгалтууд (бичгээр, амаар, практик, бие бялдрын гэх мэт), бичгээр шалгуурууд авах, сурагчдын олон нийтийн үйл ажиллагааг хянах, бусад багш нартай хоорондоо зөвлөлдөх, хэрэв хэрэгцээтэй бол, сэтгэл зүйн ба эрүүл мэндийн ажилтнуудын зөвлөгөө авах зэрэг орно.
- d) Ерөнхий боловсролын 2-р ба 9-р ангийн сурагчид хичээл бүрт дор хаяж хоёр зэрэглэлтэй байх ёстой. Багш нар ангилалын бүх хугацаанд тохируулсан зэрэглэл хийх ёстой. Ангилалын хугацаанд сурагчдыг бүх хугацаанд сурсан агуулгаар дахин амаар шалгалт өгөхийг зөвшөөрөхгүй. Шалгалтыг нийт ангийн өмнө хийнэ, ганц ганцаар багшийн өреөнд шалгалт авах хориотой. Үүнд харин хөгжлийн өөрчлөлттэй нь оношлогдсон ба сэтгэцийн эмчийн хяналтан дор тайлганалтай, түүнийг зөвшөөрсөн тохиолдолд үйлдэж болох юм.
- e) Багш нь сурагчдад ангилалын хариу дүнг гардуулж, ангилалыг батлан тайлбарлаж, дүгнэсэн байдал, ур чадвар ба бүтээлүүдийн эсрэг ба эерэг нөхцлүүдийг цохон тэмдэглэж өгнө. Амаар авсан шалгалтын дараа багш нь шалгалтын хариуг сурагчид зарлана. Бичгээр хийсэн шалгалтын дүн ба баримтууд болон практик үйл ажиллагааг сурагчид 14 хоногийн дотор зарлах ёстой. Багш нь дүнгийн хариуг хэлэх ба сурагчийн ёс зүйн төлөөлөгчдүүдэд ангилалыг дамжуулаж, сурагчдын дэвтэрт бичлэг хийж, энэ хугацаандаа мөн сурагчдад тэдний дүнг дамжуулах үүрэгтэй.
- f) Бичсэн шалгуурууд ба шалгалтын бусад төрлүүдийг багш өөрөө хичээлийн жилдээ цагаар тохируулан хуваарилах ба тэд аливаа нэгэн хугацаанд бүгдийг нэг дор хуримтлуулах ёсгүй.

Бичгээр авах шалгалтуудын хугацаа 25 минутаас хэтрэхгүй байх ба багш шалгалтын өмнө үүнийг сурагчдад зарлана. Тэр бусад багш нарт ангийн бичлэг хийж үүнийг мэдээллэнэ. Нэг өдөрт сурагч зөвхөн нэг шалгалт өгнө.

- g) Багш сурагч бүрийн ангилалын системчилсан бичлэг хийх шаардлага хариуцлагатай бөгөөд тэр сурагчдын бүхэл ангиллын зөв байдлыг нотлох нотолгоотой байх нь чухал бөгөөд дүнг ямар аргаар тавьсан (амаар эсвэл бичгээр шалгалт авсан гэх мэт) зэрэг баримттай байх ёстой. Ангилалын хугацаанд тус багш удаан хугацаагаар хичээл заагаагүй эсвэл ажил нь

дууссан тохиолдолд ангилалыг орлох багш буюу сургуулийн удирдлагын ажилтан гүйцэтгэнэ.

- h) Ангилалын зэрэглэлийг уг хичээлийн сэдэв заадаг багш тодорхойлно. Хэрэв сургач сургуулиас гадуур удаан хугацаагаар байсан, хичээлд ирээгүй тохиолдолд (спа эмчилгээ, эрүүл мэндийн шалтгаанаар байхгүй байх, бусад байгуулаагуудаар хэсэг хугацаанд үйлчлүүлсэн байх гэх мэт), багш нь сургачийн ангилалыг тэмдэглэж, түр шилжсэн сургууль ба байгууллагатай холбоо барих үүрэгтэй, үүнд сургачаас дахин шалгалт авахгүй.
- i) Ангилалын хугацааны эцэс бүрт хичээл бүрийн дүнг тодорхойлж байхдаа, сургачийн бүх ангилалын хугацаанд олсон амжилт ба хичээлийн дүн, ажлын чанар зэргийг тодорхойлно. Зохих хугацаанд ангилалын дундажийг харгалзаж зэрэглэлийг тодорхойлохгүй. Ангилалын хугацааны эцсийн зэрэглэл нь сургачийн авсан дүнд тохирох ёстой ба эцэг эхэд нь дамжуулна.
- j) Сургач хичээл сурж эзэмшихдээ хоцрох заншилтай ба сахилга муутай байхад үүнийг сурган хүмүүжүүлэгчийн зөвлөлөөр авч хэлэлцдэг ба энэ нь 11-р сарын 15 болон 4-р сарын 15-нд ноогддог.
- k) Ангилалын хугацааны эцэст сургуулийн тэргүүлэх багшийн тодорхойлсон огноонд, гэхдээ сурган хүмүүжүүлэгчдийн ангилалын тухай уулзалтаас 48 цагаас хэтрэлгүй хугацаанд зохих хичээл хариуцсан багш нар ангилалыг каталогийн хуудсанд тэмдэглэж, дахин хянах шалгуур зэргийн талаар санал бодлоо солилцно.
- l) Сургачийн хууль ёсны төлөөлөгч нь сургачийн зэрэглэл ба сахилгын тухай мэдээлэл авах ёстой: хэрэв хууль ёсны төлөөлөгч хүсэлт гаргасан бол нэгдүгээр ба хоёрдугаар хагас жилийн дундуур ангийн багш эсвэл хувийн багш нар, ангийн багш эсвэл багш байлцах шаардлагатай.
- m) Мэдээллийг эцэг эх нарт хувийн уулзалт эсвэл ангийн уулзалт эсвэл дуудлагын үеэр дамжуулна. Үүнд эцэг эх нарыг бичгээр урьсан байна. Сургуулиас тодорхойлогдсон огноонд ирж чадаагүй эцэг эх нарт хувиараа хүрэлцэн ирэх боломж олгоно. Сургачийн сахилга, бие авч явах байдлын дүгнэлт ба мэдээллийг олон нийтэд зарлахгүйгээр сургачийн төлөөлөгчдөд мэдэгдэнэ.
- n) Сургачийн дүн гэнэт ердийн бусаар өөрчлөгдсөн бол тус хичээлийн багш эцэг эх нарт үүний тухай яаралтай мэдэгдэл хийж өгөх ёстой.
- o) Хэрэв сургачийн ангилал түүний бичгэн ажлууд болон график ажлуудаар тодорхойлогдож байгаа бол багш нь түүний ангилалыг тодорхойлсоноор нь байлгах эсвэл сургачийн хууль зүйн төлөөлөгчийн үүний тухай санал гаргахыг хүлээнэ, үүнд бүхэл хичээлийн жилд тохиох сургуулийн амралтын хугацаа орно, түүнийг дуудаж ярилцаж болох ба хэрвээ сургачийн ангилалыг хойшлуулсан эсвэл дараачийн хичээлийн жилийн 10-р сарын 30 хүртэл засах шалгалт томилтол санал гаргаж болно. Засссан бичгээр үйлдсэн баримтуудыг бүх сургачдад гардуулна, мөн эцэг эх нарт тэдний хүсэлтээр баримтыг олгож болно.
- p) Багш нар сурган хүмүүжүүлэх ёс суртахууныг баримтлана, тэд сургачдыг долоо хоногоос илүү хугацаагаар сургуульд ирээгүй байгаад ирэхэд нь

тэдний ангилалыг зохицуулах ёсгүй, сурагчдад өөрсдийнхөө хичээлд ирээгүй хугацааны ажлыг давтан хийх шаардлагатайг мэдээлж, хэрвээ тэдэнд мэдээллийн эх сурвалж байхгүй бол хяналтын шалгалт өгөхийг санал болгоно. Санал болгож байгаа шалгалт нь сурагчдын мэдлэгт алдаа хайх биш харин тэдний энэхүү үеийн мэдлэгийг тодорхойлох зорилготой бөгөөд багш нь тэдний юу сурсан ба бие даан суралцахад анgid шинэ материалууд хүрэлцэхгүй бол шалгалтын өмнө сурагчид үүнд бэлдэх, практикийн сургалт дахин хийх ба хичээлийг ойлгуулах цаг хугацаа өгөх, хичээлийн мэдлэгийн дүгнэлтийг тус хичээлийг ойлгож сурсны дараа үйлдэх нь чухал.

- q) Ангийн багш нар (боловсролын зөвлөх) бусад багш нарт мэдээлэл авах арга барил болох, сурагчдыг дүгнэх ба ангилах арга барил болох сэтгэл зүйн дүгнэлтийн зөвлөгөөтэй танилцуулах ёстой. Шинэ шалгалтын мэдээлэлүүд багш нарын /боловсролын зөвлөх нарын/ сурган хүмүүжүүлэх зөвлөлийн тайлагналын нэг хэсэг болж өгдөг.

10. Тусгай төрөлжсөн боловсрол хэрэгцээтэй хүүхдүүдийг дүгнэх арга барил

- a) Тусгай төрөлжсөн боловсрол хэрэгцээтэй хүүхэд, сурагч ба оюутан гэж тахир дутуу, эрүүл мэндийн өөрчлөлттэй эсвэл нийгмийн эмзэг хүнийг хэлнэ. Сургуулийн Дүрмээр бол энэ нь сэтгэцийн, бие махбодийн, хараа эсвэл сонсголын өөрчлөлтүүд, ярианы өөрчлөлт, олон төрлийн хослосон өөрчлөлтүүд, аутизм ба хөгжлийн хоцролт болон зан араншингийн өөрчлөлтүүд юм. Эрүүл мэндийн сул талууд бол эрүүл мэндэд гарсан хөнгөн хэлбэрийн өөрчлөлтүүд суралцах чадварыг багасгаж, бие авч явах байдалд өөрчлөлт оруулдаг ба энэ байдлуудыг суралцах чадварт нөлөөтэй гэж үздэг. Нийгмийн талаас гарах сул талууд бол гэр бүл нь дорой нийгэм соёлын байдалтай байвал нийгмийн эмзэг хэсэгт оруулж түүнийг хамгаалах боловсрол эсвэл зохих байгууллагын боловсрол шаардах, үүнд цагаачлал орогногч хайгчийн байдал болон Чех улсад цагаачлал орогнол хайгчийн байдал мөн адил ордог.
- b) Тусгай боловсрол авах хэрэгцээтэй хүүхдүүд, сурагчид ба оюутнууд боловсролын нөхцлүүд ба суралцах болон ангилалд хамаарах эрхтэй.
- c) Тусгай боловсрол авах хэрэгцээтэй хүүхдүүд, сурагчид ба оюутнуудыг дүгнэж байхад түүний тахир дутуу байдал эсвэл сул талуудыг харгалзаж үзэх хэрэгцээтэй болдог. Багш нар сурагчийн сэтгэл зүйн үзлэгээр гаргасан зөвлөгөөг анхаарч үүнийг сурагчийн зан байдлын ангилал хийхдээ харж үзэх ёстай бөгөөд ухаалаг хандах нь чухал.
- d) Сурагчийн биеийн хөгжлийн өөрчлөлт нотлогдсон тохилдолд тэргүүлэх багш сурагчийн хууль ёсны төлөөлөгчийн хүсэлтээр амаар дүгнэлт хийх ёстай.

- e) Сурагчийн мэдлэг ба ур чадварын үе шатыг тодорхойлоо багш нь сурагчийн чадварт тохирсон шалгалтыг сонгодог ба энэ нь өөрчлөлтүүдэд эсрэг нөлөө үзүүлэх ёсгүй. Хяналтын шалгуур тестууд ба цээж бичиг зэргийг өмнө нь зөвхөн энэ сурагч наарт зориулж бэлдэх ёстой. Хэрэв хэрэгцээтэй бол, өөрчлөлттэй сурагчдад өөрийнх нь ур чадлаар хийж гүйцэтгэж огт чадахгүй даалгавар өгөхгүй байх нь чухал.
 - f) Багш нь сурагчийн арай чадварлаг хийж чадах илэрхийллийн хэлбэрийг дэмжиж тусална. Ангилалыг алдааны тоон дээр биш, харин сурагчийн амжилттай үйлдсэн үйлдлийн тоонд тулгуурлан хийнэ.
- a) Ангилалыг хяналтын ажилтай хавсаргаж дүгнэнэ, жишээ нь, үйлдлийн эерэг талуудыг илэрхийлж, алдааны байдлыг тайлбарлаж, бэрхшээл дутагдлыг яаж давж гаражыг тайлбарлана.
 - b) Сурган хүмүүжүүлэх арга хэмжээг эцэг эх нартай нь хамтран шийдэж тэдний зөвшөөрсөн болон зөвшөөрөөгүй санал бодлыг хүндлэн хүлээн авна.
 - c) Дүгнэх үйл явцдаа багш нь сурагчийнхаа эерэг ур чадваруудыг илрүүлэх хандлагаар хандах бөгөөд үүгээрээ түүний сурх чадвард анхаарлыг нь төвлөрүүлэх бөгөөд түүний алдаа дээр анхаарлаа төвлөрүүлэх хандлагыг бууруулахыг чармайна.
 - d) Тусгай сургалт шаардсан сурагчид ба хэт авьяаслаг хүүхдүүд бага сургуулийн боловсрол олгох явцад аль нэг өөр тусгай заалт байхгүй бол боловсролын 48/2005 Тогтоолыг харгаргалзан дагана.

11. Хэт авьяас чадвартай хүүхдүүд, сурагчид ба оюутнуудын боловсрол

- a) Сургуулийн тэргүүлэх багш нь хэт авьяаслаг бага насы сурагчдыг өмнөх хичээлийн жилд оролцуулгүйгээр дараачийн хичээлийн жил рүү шилжүүлж болно. Шилжүүлэхдээ хичээлийн жилийн сургалтын хөтөлбөрийн шалгалт авах ба түүний оролцохгүй хичээлийн жилийн хөтөлбөөр шалгалт авч болно. Шалгалтын агуулга ба хамрах хүрээ нь сургуулийн тэргүүлэх багшаар тодорхойлогддог.
- b) Хувиараа хичээллэж байгаа хүүхэд өөрийн элссэн сургуулийн хагас жил бүрт зохих хичээлийн шалгалт өгөх шаардлагатай. Хувиараа боловсрол авч байгаа сурагч хагас жил бүрийн эцэст шалгалт өгөх боломжгүй, үүнд сургуулийн тэргүүлэх багш нь шалгалт өгөх огноог тодорхойлох бөгөөд энэхүү шалгалт нь хагас жил бүрийн эцсээс тоолон хоёр сараас хэтрэлгүй хугацаанд тодорхойлогдоно. Сургуулийн тэргүүлэх багш нь хэрвээ сурагч хоёр дахь хагас жилд шалгалтандaa унасан буюу зохих хугацаанд шалгалтаа өгж чадаагүй тохиолдолд хуваираа боловсрол олгох байдлыг цуцалж болно.

12. Зохисгүй болон эрсдэлтэй байдлыг шуух дурмууд

- a) Сургуулийн Дүрмийг зөрчсөн тохиолдолд зөрчлийг дүгнэх ойлгомжтой дүрэм боловсруулах нь сургуулийн уур амьсгалыг зөв цэгцтэй байлгахад шаардлагатай.
- b) Бага сургуулийн сурагчдын сахилгыг тооцсон эрсдэлтэй зүйлээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн дагуу доорх журмуудыг гаргасан. Сургуулийн Дүрмийг зөрчсөн тохиолдолд зохих арга хэмжээ авахаар тодорхойлогдсон:
- c) Бид хууль ёсны төлөөлөгчдөд Сургуулийн Дүрмийг зөрчсөн тохиолдлыг маш яаралтай ба хурдан мэдээлж, сахилга бат биеэ авч явах дүрмийг тайлбарлах ба хэргийн улмаас аливаа нэгэн үр дагавар гарсан эсэхийг тогтоож (хэрэв архины төрөл болон бусад аливаа нэгэн хортой бодис хэрэглэх) үүнийг шуурхай байдлаар хууль ёсны төлөөлөгчид мэдээлж, ноцтой зөрчил гарсан бол эмч, Чех улсын Цагдаагийн байгууллагатай холбоо барих ба хүүхэд хамгаалах нийгмийн болон хууль зүйн ажилтанд мэдэгдэнэ.

Сахилгын арга хэмжээ ба сахилгын ангилал

- a) Нэг буюу давтагдсан удаа Сургуулийн Дүрмийн зөрчих нь сахилгын арга хэмжээ авахад хүргэх буюу ангилалын хугацааны эцэст сахилга батын зөрчилийг сахилга бат, бие авч явах ангилалд тусгаж бичнэ.
- b) Сургуулийн дүрмийг зөрчих нь зөрчилийн байдлаас хамаарч сахилгын арга хэмжээ авах зохих шийтгэлтэй:
 - Ангийн багшийн сануулга;
 - Ангийн багшийн шүүмжлэл;
 - Тэргүүлэх багшийн шүүмжлэл.
- c) Сахилгыг үнэлэх өөр нэгэн хэрэгсэл бол ангилалын хугацааны эцэст үе шатлалаар хуваж ангилах арга:
 - a. Сахилгын Зэрэглэл 2
 - b. Сахилгын Зэрэглэл 3
- d) Сургуулийн Дүрмийг ноцтой зөрчсөн тохиолдолд сахилгын зэрэглэл болон өмнө нь ямар нэгэн сахилгын арга хэмжээ авахыг үгүйсгэж болно. Ялангуяа сурагч сургуулийн ажилчдыг үгээр эсвэл үйлдлээр доромжлох нь Сургуулийн Дүрмийг ноцтой зөрчсөн тохиолдол гэж тооцно. Сургуулийн тэргүүлэх багшийн оролцоотой сурган хүмүүжүүлэх зөвлөлийн ярилцлагаар орсны дараа ямарваа нэгэн сахилгын арга хэмжээ авч болно. Багш эсвэл ангийн багш нь сурагчийн үйлдлийг уучлах тухай тодорхой бичлэг хийх ба хэргүүдийн хүндээс шалтгаалж хэргийг уучлах шийдвэр гаргаж болно. Багш нь зохих хичээлийн эсвэл сургуулийн арга хэмжээнд гарсан зөрчлийг уучлах бичлэгийн дүрмийг зохиож, зохих сурагчдад үүнийг урьдчилан танилцуулна. Сурагч үүнийг тайлгахаа шаардлагатай, хэрэв хэрэг гарвал бичлэгийнхээ дэвтэрт бичиж тэр өөрөө бичиж тэмдэглэнэ.

- e) Нэгдүгээр ба хоёрдугаар жилүүдэд хэрэг уучлах үйл явц нь багшаар тэмдэглэгдэж бичигдэнэ.
- f) Сургуулийн Дүрмийг зөрчсөн бага зэргийн зөрчлийн тоонууд, өршөөсөн хэргүүдийн тоо ба Сургуулийн Дүрмийн зөрчлийн түвшинг сургач бүрт сарын эцэст ангийн багш дүгнэж тэмдэглэнэ.
- g) Сахилга нь ангилалын хугацаанд багтаж дүгнэгдэнэ (хичээлийн хагас жил). Анги хариуцсан багшийн шүүмжлэл сануулга нь тэр даруй хэрэгжиж эхлэх ёстой ба бусад сахилгын арга хэмжээ нь сурган хүмүүжүүлэгчдийн зөвлөлийн ярилцлагын дараа хэрэгжиж эхлэнэ. Зэрэглэлийн ангилал нь ангилалын хугацаа дуусахад хийгдэнэ.

Сургуулийн Дүрмийг зөрчсөн хамгийн ердийн тохиолдолд хийх дүгнэлтийн жишээний тойм

Сургуульд ирээгүй тохиолдлууд

Сургач сургуулийн хичээлд зохих журмыг даган хүрэлцэн ирэх үүрэгтэй ба өөрийгөө боловсруулах үүрэгтэй.

Эцэг эх нар сургач нарыг хичээллээс шалтгаантайгаар чөлөөлөх эрхтэй. Хэрэв шалтгаангүй ирээгүй цагийн тоо 22 эсвэл үүнээс дээш байвал үүнийг нийгмийн ба хуулиар хүүхэд хамгаалах зохих байгууллагад тайлагнах хэрэгтэй.

Шийтгэлийн хүрээ:

- (a) шалтгаангүй хичээлд ирээгүй цагийн тооны дагуу – ангийн багш сахилгын зэрэглэлийг багасгах арга хэмжээ авна;
- (b) дур зоргоороо сургуулиас гарч явах – тэргүүлэх багшийн шүүмжлэл, сахилгын зэрэглэлийг бууруулах.

Сургууль доторх хүчирхийлэл

Бусдад зориудаар гэмтэл учруулсан тохиолдлыг үүний давталт ба хүндээс хамаарч дүгнэнэ.

Шийтгэлийн хүрээ:

- (a) анхны хэрэг – хэргийн хүндээс хамаарна – тэргүүлэх багшийн зэмлэл шүүмжлэл;
- (b) давтагдах хэрэг – сахилгын зэрэглэлийг бууруулах.

Дээрэлхэх доромжлох

Боловсрол Залуучууд Спортын Яамнаас гарах зааварчилгааг дагаж дээрэлхэл ба доромжлолын байдлыг мөрдөж, нотолж шийднэ.

Шийтгэлийн хүрээ:

- (a) доромжлолын шинж – хүндээс хамаарна – ангийн багшийн зэмлэл шүүмжлэл, тэргүүлэх багшийн шүүмжлэл;
- (b) батлагдсан дээрэлхийлэл – сахилгын зэрэглэлийг бууруулах.

Эд өмч эвдэх

Өөрсдийн үйл ажиллагаанаас болж үүссэн эвдрэл гэмтэлд хүн бүр хариуцлага хүлээнэ. Сургуулийн өмч эвдэж нураасан тохиолдолд сургууль үүнийг үйлдсэн хүнээс хохиролыг төлөн барагдуулахыг шаардана.

Шийтгэлийн хүрээ:

Сургуулийн өмч эвдэх:

Дүгнэлтийг доорх байдлаар эвдрэл ба тус эвдрэл яаж болсон нөхцлүүдээс хамаарч хийдэг.

- (a) нэг удаа – ангийн багшийн зэмлэл шүүмжлэл;
- (b) давтагдсан – хэрэг хийсэн удаагаас хамаарна ангийн багш эсвэл тэргүүлэх багшийн шүүмжлэл;
- (c) хэрэв сурагч өмнө авсан арга хэмжээг тоохгүй ба цаашдаа сургуулийн эд өмчийг эвдэх нь хэвээр байвал түүний сахилгын зэрэглэлийг бууруулна.

Хулгай

Чех улсад хэн нэгний өмчийг хулгайлах нь үүссэн хохиролын хүндээс хамаарч эрүүгийн хэрэг эсвэл халдалт гэж тооцдог.

Шийтгэлийн хүрээ:

Хувийн өмч буюу сургуулийн өмч хулгайлах:

- (a) сурагчийн сахилгын зэрэглэлийг бууруулж сурагчийг шийтгэх;
- (b) мөрдөлтийн үед сурагч ба түүний хууль ёсны төлөөлөгч хоорондоо идэвхтэй хамтран ажиллавал арай зөвлөн сахилгын арга хэмжээ авна.

Эрүүл мэндэд хортой зэвсэг ба зүйлс биедээ авч явах

Шийтгэлийн хүрээ:

- (a) биедээ авч явах ба үүнийг хэрэглэхгүй байх – ангийн багшийн зэмлэл шүүмжлэл, ангийн багшийн зэмлэл, тэргүүлэх багшийн зэмлэл;
- (b) хортой зүйл хэрэглэх – тэргүүлэх багшийн зэмлэл, сахилгын зэрэглэл хасах.

Согтууруулах ундаа, мансууруулах бодис, тамхины төрлийн бүтээгдэхүүн

Сурагч нар согтууруулах ундаа хэрэглэх, мансууруулах бодис хэрэглэх, тамхи татах хориотой ба үүнийг сургуульдаа авчрахыг хориглодог. Үүний хажуугаар, эрүүл мэндийн үүднээс, согтууруулах ундаа мансууруулах бодис хэрэглэсэн байдалтай сургуульд орох нь хориотой.

Сургуульд тамхи татах нь **огт хориотой**, энэ бол хууль зөрчиж байна гэсэн үг. 18 наснаас доош насныханд согтууруулах ундаа зарах, өгөх ба зөвшөөрөх нь эрүүгийн хэрэг гэж тооцно. Энэ тохиолдолд сургууль өөрийн үүргээ гүйцэтгэж үүнийг тайлагнан Чех улсын Цагдаагийн газар үүнийг мэдэгдэх шаардлагатай. Хэрвээ сургууль нь ийм зан байдлыг мэдсэн бол үүнийг хууль ёсны төлөөлөгч ба нийгэм хуулийн ажилтангуудад тайлагнах учиртай. Энэ нь мөн адил сургуулийн арга хэмжээнүүдэд хамаарна.

Шийтгэлийн хүрээ:

Сургууль дотор, сургуулиас авч байгаа арга хэмжээний үед ба сургуульд ирэхээс өмнө дээр дурьдсан бодисууд хэрэглэсэн бол

- (a) тэргүүлэх багшийн зэмлэл, сахилгын зэрэглэл бууруулах.

Дээр дурьдсан бодисуудыг тараах

- (b) сахилгын зэрэглэл бууруулах.

Хэрэв сурагч тамхи татдаг гэж сэжиглэгдсэн бол (мэдээлэл авсан, чөлөөт цагаар хэрэглэдэг гэж сэжиглэгдсэн) бол сургууль үүнийг эцэг эх нарт эсвэл хууль ёсны төлөөлөгчид тайлагнана.

Сургуулийн Дүрмийг хөнгөн байдалтай зөрчих нь

Шийтгэлийн хүрээ:

Үүний давтамж ба хүндээс хамаарч зэрэглэлд оруулна - ангийн багшийн зэмлэл Ангийн багшийн шүүмжлэл, тэргүүлэх багшийн зэмлэл, сахилгын зэрэглэл бууруулах,

Сургуулийн Дүрмийг зөрчсөн бол сургууль үүний тухай мэдээлэл авсны дараа шууд мөрдөж эхэлнэ, хэцүү байдалд 30 хоногийн дотор үйлдэнэ. Сахилгын арга хэмжээ эсвэл сахилгын зэрэглэл бууруулахыг санал болгосон бол сурган хүмүүжүүлэгчдийн зөвлөлөөр авч хэлэлцэнэ. Сурагч ба хууль зүйн төлөөлөгч нар эцсийн сахилгын авах арга хэмжээг шийднэ.

Бичлэгийн дэвтэр гээх, алдах

Шийтгэлийн хүрээ:

(a) бичлэгийн шинэ дэвтэрийн үнийг төлөх;

(b) Байнга хичээл тасалж байгаа тохиолдол – ангийн багшийн зэмлэл; цаашдын алга болгох гээх – тэргүүлэх багшийн зэмлэл; дараагаар, сахилгын зэрэглэл бууруулах. Сурагч хувийн багшаар бөглөгдсөн зэрэглэлийг байнга хангах хариуцлага хүлээнэ.

Сургуулийн Дүрмийг зөрчсөн хамгийн ердийн тохиолдолд хувийн сахилгын арга хэмжээ авсан жишигүүдийн тойм:

Заагаагүй тохиолдлуудад ангийн багш нь сахилгын арга хэмжээ авахыг шийднэ, илүү ноцтой хүнд тохиолдлуудад тэргүүлэх багш сахилгын арга хэмжээг сурган хүмүүжүүлэгчдийн зөвлөлөөр орсны дараа шийднэ.

(a) ангийн багшийн сануулга

Ангид үймүүлж саад болох;

Бүдүүлэг яриа уг хэрэглэх;

Солих гуталгүй;

Сургуулийн өмчийг нэг удаа бага зэргээр эвдсэн;

Сургуулийн гуанзын сахилгын дүрмийг мөрдөөгүй;

Гар утас, хөгжим тоглуулагч ба бусад холбооны хэрэгслүүд хэрэглэх, гэрэл зураг авах, сургуулийн зөвшөөрөлгүй аудио ба видео бичлэг хийх

Завсарлагааны үед Сургуулийн Дүрэм зөрчих;

Ангийнхаа хүүхдэд зориуд халдах – нэгдүгээр тохиолдолд;

З удаа учлалын бичлэг;

З удаа Сургуулийн Дүрэм зөрчсөн ба сахилгын зөрчлийн бичлэгүүд.

(b) ангийн багшийн зэмлэл

Сургуулийн Дүрмийг цаашид даван зөрчиж, өмнөх зөрчлөөс илүү ноцтой зөрчил үйлдэх;
Өмнө нь авсан арга хэмжээг хүндэтгэхгүй байх;
Давтан бүдүүлэг хэллэг хэрэглэх;
Сургуулийн эд өмчийг эвдэх сүйтгэх;
Ангийнхныхаа өмчийг сүйтгэх;
Бичгийн шалгалт ба шалгууруудад заль хэрэглэх, хуурах, зэрэглэлийг бичлэгийн дэвтэрт хуурамчаар бичих;
Гар утас, хөгжим тоглуулагч ба бусад холбооны хэрэгсэл давтан хэрэглэх ба сургуулийн зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, аудио видео бичлэг хийх
Бичлэгийн дэвтэрийг байнга алдах
5 удаа уччалын бичлэг;
5 удаа Сургуулийн Дүрэм зөрчсөн ба сахилгын зөрчлийн бичлэгүүд.
Пиротехник ба эрүүл мэндэд аюул учруулах бусад зүйлс (хэрэглэхгүйгээр сургууль ба сургуулийн арга хэмжээнд авчрах).

(c) тэргүүлэх багшийн зэмлэл

Сургуулийн Дүрмийг цаашид даван зөрчиж, өмнөх зөрчлөөс илүү ноцтой зөрчил үйлдэх нь ихсэх;
Өмнө нь авсан арга хэмжээг хүндэтгэхгүй байх;
Сургууль ба сургуулиас гадуур байгууллагуудад болох сургуулиас зохион байгуулж буй арга хэмжээний үеэр тамхи татах – нэгдүгээр хэрэг;
Байнгын бүдүүлгээр биеэ авч явах;
Пиротехник ба эрүүл мэндэд аюул учруулах бусад зүйлс (сургууль ба сургуулийн арга хэмжээнд авчрах, үүнийгээ хэрэглэх)
Дур зоргоороо сургуулиас гарч явах;
Бичгийн шалгалт ба шалгууруудад байнга давтан заль хэрэглэх, хуурах, зэрэглэлийг бичлэгийн дэвтэрт хуурамчаар бичих;
8 удаа уччалын бичлэг;
8 удаа Сургуулийн Дүрэм зөрчсөн ба сахилгын зөрчлийн бичлэгүүд.
Шалтгаагүй хичээл таслах – 3 цагаас илүү;
Хүний бие рүү халдан дайрах ба бусдын эрүүл мэндэд санаатайгаар халдах.

(d) Сахилгын зэрэглэл бууруулах – зэрэглэл 2

- Сургуулийн Дүрмийг цаашид зөрчиж, өмнөх зөрчлөөс илүү ноцтой зөрчил үйлдэх, ихсэх;
- Өмнө нь авсан арга хэмжээг хүндэтгэхгүй байх;
- Зэрэглэлийг ихсгэж хуурамчаар бичих;
- Байнга давтагдах бүдүүлэг зан араншин байдал;
- Сургуулийн ажилчид ба сурагчдыг байнга үгээр доромжлох, дээрэлхэх;
- Сургуулийг дур зоргоороо байнга орхиж явах;
- Сургуулийн байранд тамхи татах, үүнд сургуулиас гадуур болох сургуулиас зохион байгуулж буй арга хэмжээ орно – давтагдсан
- Эрүүл мэндэд зориудаар хохирол учруулах – давтагдсан эсвэл том үйлдлүүд;
- Сургууль ба сургуулиас гадуур байгууллагуудад болох сургуулиас зохион байгуулж буй арга хэмжээний үеэр согтууруулах ундаа, мансууруулах бодисууд хэрэглэх;

- Давтагдсан үгээр доромжлох байдлууд гаргах (үгээр гутаах, доромжлох, дээрэлхэх, гүтгэх);
- Хулгай хийх
- Ангийн багшийн шүүмжлэл, ангийн багшийн зэмлэл ба тэргүүлэх багшийн зэмлэл хийсэн ба үүнийг огт тоохгүй байх;
- Шалтгаангүй хичээл таслах – 4-өөс 7цаг;
- 10 удаа уучлалын бичлэг;
- 10 удаа Сургуулийн Дүрэм зөрчсөн ба сахилгын зөрчлийн бичлэгүүд.

(e) Сахилгын зэрэглэл бууруулах – зэрэглэл 3

- Сургуулийн Дүрмийг цаашид даван зөрчиж, өмнөх зөрчлөөс илүү ноцтой зөрчил үйлдэх, ихсэх;
- Сургуулийн Дүрэм зөрчих нь өмнөхөөсөө ихсэх;
- Өмнөх авсан өргө хэмжээг хүндлэхгүй байх;
- Эрүүл мэнд хохиросон зоридаар бусдад халдах;
- Нотлогдсон доромжлол – шууд, идэвхтэй (амаар эсвэл бие махбодид халдах);
- Нотлогдсон доромжлол – шууд бус, идэвхтэй (хохирогч руу дайрахыг санал болгох дэмжих);
- Хулгай давтагдах;
- 8-21 цагийн шалтгаангүй хичээл таслах;
- Сургуулийн Дүрмийг маш ноцтой зөрчих;
- Ангийнхандаа, багш нарт эсвэл сургуулийн ажилтнууд руу сэтгэл санааны халдлага хийх.

13. ЭЦСИЙН ТОЙМ

Ангилалын Дүрмүүд нь Сургуулийн Шинэ Дүрмүүд гардуулах хүртэл хүчинтэй. Ангилалын Дүрмүүдийг Сурган Хүмүүжүүлэх Зөвлөл 2018 оны 8-р сарын 30-нд авч хэлэлцсэн ба

Ангилалын Дүрмүүд Сургуулийн зөвлөлөөр –нд дэмжигдсэн

Ангийн багш нар сурагчдад Сургуулийн Дүрмийг танилцуулсан.

Сурагчдын хууль ёсны төлөөлөгчид Сургуулийн Дүрмийн тухай мэдэгдсэн ба тэд үүнийг бичлэгийн дэвтэрт бичвэр оруулж баталгаажуулсан.

Ангилалын Дүрмүүд зохих байдлаар хэвлэгдсэн.

Ангилалын Дүрмүүд –ээс хүчинтэй болно.

201... оны 9-р сарын 1-нд

Тэргүүлэх багш

Ангилалын Дүрмийг удирдах эрх зүйн дүрмийн ерөнхий тойм:

Сургуулийн өмнөх насны, бага, дунд, дээд мэргэжлийн ба бусад сургалтын (Боловсролын Акт) 561/2004 дугаарын Акт, одоогийн засвар хяналтан дор.

Дунд боловсрол ба консерваторийн боловсролын тухай 13/2005 дугаарын Тогтоол, одоогийн засвар хяналтан дор.

Ерөнхий боловсрол ба сургуульд залшгүй байдлаар ирэх тухай зарим шаардлагуудын тухай 48/2005 дугаарын Тогтоол, одоогийн засвар хяналтан дор.

Тусгай боловсрол олгох хэрэгцээтэй ба гоц авьяаслаг хүүхдүүд, сурагчид ба оюутнуудын боловсролын тухай 27/2016 дугаартай Тогтоол, одоогийн засвар хяналтан дор.